



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/39

Цагаантолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 2022 онд сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 17.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/126 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: А.Одхүү- (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүд: Л.Сэлэнгэсайхан- (Ивэн 1-р багийн Засаг дарга)  
Б.Золбаяр- (Хушаат 2-р багийн Засаг дарга)  
Ж.Лхагважаргал-(сумын Хэсгийн төлөөлөгч)  
Ц.Сонинзул- (Улсын бүртгэгч)  
Ч.Азжаргал- (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)  
Э.Очгэрэл- (Эрүүл мэндийн төвийн дарга)

2. Сумын хэмжээнд цэрэг татлагын бэлтгэл ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

3. Цэрэг татлагад 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2004 оны 05 дугаар сарын 02-ны хооронд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

4. Ажлын хэсгийн гишүүдийн чиг үүргийг томилгоожуулж, хуваарийн дагуу тогтоосон хугацаанд цэрэг татлагын ажлыг сайтар зохион байгуулж халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг ажлын хэсгийн дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Ч. Дашагзор  
Хянасан: С. Шилүүбаяр  
Хувь: 2  
Огноо: 2022 04.06